



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/191

Булган сум

Соёлын байгууллагуудын ажилтан,
албан хаагчдын дунд сургалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёл урлагийн байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоог сайжруулах, шинэ санал санаачилга хэлэлцэх, туршлага солилцох зорилгоор аймгийн Соёлын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд “Соёлын түүчээ 2024” арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг хавсралтаар баталж, “Бүх нийтийн соёлын боловсрол”-ыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 01-ны өдрийн А.А.191 дугаар
захирамжийн хавсралт



“Соёлын түүчээ 2024” арга хэмжээний төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Цомын шагнал	2 сум	500,000	1,000,000
Нийт үнэ				1,000,000